



МОНГОЛ УЛСЫН
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД

Нэгдсэн үндэстний гудамж 5,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 15 53, Факс: 32 86 34,
Цахим шуудан: info@mlsp.gov.mn
Цахим хуудас: www.mlsp.gov.mn

2025. 11. 13 № 01/3659

танай _____-ны № _____-т

Тайлбар хүргүүлэх тухай

Танаас 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 48 дугаар албан бичгээр ирүүлсэн асуулгатай танилцаж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар дараах тайлбарыг хүргүүлж байна. Үүнд:

1.2023 оноос хойших үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зохион байгуулалт, хүрсэн үр дүнгийн талаар:

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль (1994.06.07)-ийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан арга хэмжээний зардлын хэмжээ, санхүүжүүлэх журмыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална.” гэж заасны дагуу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны 10 дугаар тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх журам”-ыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хэрэгжүүлсэн.

Энэхүү журмын 2.1-д “Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн тухай жилийн шимтгэлийн орлогын 1 хувиас хэтрэхгүй байна” гэж заасан.

Мөн 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж байгаа Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт “Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төлбөр нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн тухайн жилийн шимтгэлийн орлогын 2 хувиас багагүй байна” гэж заасан.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны 10 дугаар тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх журам”-ын дагуу “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжих урьдчилан

сэргийлэх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөө"-нд тусгагдсан 64 арга хэмжээнээс 44 арга хэмжээг зохион байгуулсан байна. Үүнд:

-Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн эрсдэл өндөртэй ажлын байранд ажиллаж буй 10.1 мянган даатгуулагчдад үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт хийсэн;

-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр 14 арга хэмжээ зохион байгуулж, бүх төрлийн хэвлэл, мэдээллийн байгууллага, хуулийн эмхэтгэл, ном, гарын авлагаар дамжуулан давхардсан тоогоор 505.0 мянган даатгуулагчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх талаарх зөвлөгөө, мэдээлэл өгсөн;

-Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн үзлэг, судалгаа, үнэлгээ зохион байгуулах, бодлого, стандартыг боловсронгуй болгох чиглэлээр 17 арга хэмжээг зохион байгуулж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйтай холбоотой 8 стандартыг шинэчлэн баталж, ажил олгогч, даатгуулагчдад сурталчилахаас гадна, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдах мэдээлэл, тооцоололтой холбоотой судалгааны ажлуудыг тус тус хийж гүйцэтгэсэн.

Мөн 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж байгаа Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэгт заасны дагуу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 07 дугаар тогтоолоор "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг сонгох, арга хэмжээний зардлын төлбөрийг санхүүжүүлэх, хяналт тавих журам", 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор баталсан "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжих урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2024 оны төлөвлөгөө"-г тус тус баталсан.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжих урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2024 оны төлөвлөгөөгөөр 4 чиглэлийн нийт 26 арга хэмжээ зохион байгуулах бөгөөд 2 арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүнд:

- 1.0 мянган даатгуулагчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт;

- шинэ техник, технологи, инновац нэвтрүүлсэн 32 ажил олгогчийн шилдэг туршлагыг олон нийтэд сурталчилах ажлыг зохион байгуулсан.

Харин Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны "Төлөвлөгөө батлах тухай" 06 дугаар тогтоолоор баталсан "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс

шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө"-нд 62 арга хэмжээ тусган хэрэгжүүлсэн. Үүнд:

-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын үйл ажиллагаа, хууль тогтоомжтой холбоотой мэдээлэл, зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгааны 11 арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 235.0 мянган даатгуулагчид зөвлөгөө, мэдээлэл хүргэсэн;

-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын үйл ажиллагаа, хууль тогтоомжтой холбоотой мэдээлэл, зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгааны чиглэлээр 19 арга хэмжээг зохион байгуулж 9.0 мянган даатгуулагчид сургалтыг зохион байгуулсан;

-Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн, шинэ техник, технологи, инновац нэвтрүүлсэн 50 ажил олгогчийн шилдэг туршлага, ололт, амжилтыг олон нийтэд сурталчлан, түгээж, соён гэгээрүүлэх зэрэг ажлыг зохион байгуулсан.

Түүнчлэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний чиглэлээр 7 төрлийн тандан судалгааны ажлыг зохион байгуулж санал, дүгнэлт, зөвлөмж гарган Нийгмийн даатгалын багц хууль болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгах саналыг боловсруулаад байна.

Мөн 2023 онд Мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн тоо 2600, мөн 2024 онд 2282 болж жил дараалан тогтмол буурч байгаа бөгөөд өмнөх оны жилийн эцсээс 3.8 хувиар буурсан.

Харин 2023 онд Үйлдвэрлэлийн ослын улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн тоо 903, мөн 2024 онд 922 байгаа нь өмнөх оны жилийн эцсээс 2.1 хувиар өссөн байна.

Түүнчлэн 2023 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зохион байгуулалтын үр дүнд үйлдвэрлэлийн ослыг багасгах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах зорилгоор ажил олгогчид үзүүлэх хөнгөлөлт, чөлөөлөлт, даатгуулагчийн эрүүл мэндийн нөхөн сэргээлт эдгээр асуудлыг Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д тодорхой тусгаж өөрчлөлт оруулсан.

2.2023 оноос хойших урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсвийн гүйцэтгэл, зарцуулалтын талаар:

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 2023 онд 1,570.9 сая төгрөг, 2024 онд 3,302.6 сая төгрөг, 2025 онд 3,302.6 сая төгрөг, бол 2026 онд 6,468.6 сая төгрөгийг Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд тусгаад байна. Тухайлбал:

2023 онд 44 арга хэмжээг зохион байгуулж урьдчилан сэргийлэх арга хэмжээний нийт батлагдсан 1,570.9 сая төгрөгөөс арга хэмжээний зардалд 1,071.9 сая төгрөгийн санхүүжилт олгож, төсвийн гүйцэтгэл 68.2 хувьтай зарцуулсан.

Мөн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан 26 арга хэмжээнээс 2024 оны 11 дүгээр сард 2 арга хэмжээг хэрэгжүүлж, нийтдээ 45.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, төсвийн гүйцэтгэл 1.3 хувьтай зарцуулсан байна.

Харин “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан 62 арга хэмжээнээс 2025 оны 10 дугаар сарын байдлаар дараах 42 арга хэмжээг хэрэгжүүлж, 1,604.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгож 48.6 хувьтай зарцуулаад байна.

3.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасан “Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төлбөр нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн тухайн жилийн шимтгэлийн орлогын 2 хувиас багагүй байна” гэсэн шаардлагыг хэрхэн ханган ажиллаж байгаа талаар:

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас зарцуулах урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төлбөрт 2024 оны төсвийн төслийн саналыг 4,264.4 сая төгрөгөөр, 2025 оны саналыг 3,302.6 сая төгрөгөөр, 2026 оны төсвийг 4,293.3 сая төгрөгөөр тус тус тооцон Сангийн яаманд хүргүүлсэн.

Сангийн яамнаас Улсын Их Хуралд уг зардлын төсвийг 2024 онд 3,302.6 сая төгрөгөөр, 2025 онд 3,302.6 сая төгрөгөөр, 2026 онд 3,269.6 сая төгрөгөөр тус тус өргөн барьсан. 2026 онд УИХ-ын гишүүдээс гаргасан саналыг үндэслэн Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулиар уг зардлын төсвийг 6,468.6 сая төгрөгөөр баталсан.

Цаашид ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн эрүүл ахуй, эрүүл мэндийн үзлэг, тандалт, ажил мэргэжлийн тохироо, сэргээн засах тусламж үйлчилгээний талаарх зохицуулалтыг олон улсын конвенц, хэм хэмжээнд нийцүүлэн сайжруулж, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эрт илрүүлэх, хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх үр нөлөөг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндэд тавигдах шаардлагыг тодорхой болгож, өндөрт ажиллах аюулгүй ажиллагаа, хязгаарлагдмал орчин, хими, биологи, эргономик, нийгэмсэтгэл зүйн хүчин зүйлс зэрэг асуудлыг шинээр зохицуулахаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгаад байна.

Хүндэтгэсэн,



Т.АУБАКИР